

**БАГАНУУР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ТЭТГЭВЭР ТЭТГЭМЖИЙН ХЭЛТСИЙН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт							
Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах							
1.1.1.	Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах	Шаард-лагагүй	Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2023 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.	Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна.	Хуулийн шинэчилсэн найруулга, түүнтэй холбогдон гарсан эрх зүйн баримт бичиг, чиглэл, зөвлөмж заавар, аргачлалыг нэг мөр хэрэгжүүлэхээр холбогдох албан хаагчдад тухай бүр мэдээлэл хүргэж, хэрэгжилтийг зохион байгууллаа. Энэ чиглэлээр дотооддоо мэдээлэл солилцох, дээд газраас тодруулах, журамд оруулах санал хүргүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Тэтгэвэр, тэтгэмж, эмнэлгийн хуудас, сувиллын зардал олгох, тогтоох, хянах, бүрдүүлэх бичиг баримтад хяналт тавих ажиллагаатай холбоотой 2024 онд шинэчилж батлагдсан 5 журам, бусад эрх зүйн актыг хэрэгжүүлж ажиллав.	97.7
Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт							
Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах							
2.1.7.	Бусад өглөг, авлагыг барагдуулах		Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн өглөг	Бусад өглөг авлага санхүүгийн тайлангаар	а) Нийгмийн даатгалын сангийн бусад өр, авлагыг	а) Нийгмийн даатгалын сангийн бусад авлага 2023 оны жилийн эцсээр 525,1 сая төгрөг байснаас	

			авлагаас бусад өглөг, авлагыг хугацаанд нь барагдуулна.	баталгаажсан байна.	оны эхний дүнгээс 50 хувиас доошгүй барагдуулах. б) Нийгмийн даатгалын байгууллагын бусад өр, авлагыг бүрэн барагдуулах.	2024 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар 522,5 сая төгрөг болж 2,6 сая төгрөг төлөгдсөн. Уг авлага нь хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгон авч байсан 118 иргэнтэй холбоотой үүссэн авлага бөгөөд эдгээр иргэдийн холбогдох материалыг Цагдаагийн хэлтэст хэрэг бүртгэлийн хэрэг нээж, 2024 оны 08 дугаар сард Багануур дүүргийн Прокурорын газарт шилжүүлсэн. Уг асуудлыг шалгаж, эцэслэсэн шийдвэр гараагүй тул төлөлт хийгдээгүй хүлээгдэж байна. Салбарын Улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 13-07/08 дугаартай “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу тус газарт Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2024 оны 04 дүгээр сарын 08-наас 12-ны өдрүүдэд ирж ажиллав. Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч 3 иргэнд дутуу олгосон 5118,3 мянган төгрөгийг тэтгэвэр авагчид нөхөн олгох, 1 хүнд илүү олгосон 245,1 мянган төгрөгийг буцаан төлүүлэх тухай Нийгмийн даатгалын ерөнхий газрын Улсын ахлах байцаагчийн 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 32/35 дугаартай акт тогтоогдож бүрэн барагдуулсан байна.	5.0
--	--	--	---	---------------------	---	--	-----

2.1.9.	Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах		Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад тогтоогдсон тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлыг хугацаанд нь олгоно.	Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан.	а) Тэтгэврийг сар бүрийн 01-ний өдөр олгох б) Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу 106463,5 сая төгрөгийг хуульд заасан хугацаанд зарцуулсан байна.	Тус газар нь тэтгэврийг сар бүрийн 1-ний өдөр арилжааны банкаар дамжуулан олгож хэвшсэн. 2024 оны эхний 11 сарын байдлаар нийт 5643 тэтгэвэр авагчид өссөн дүнгээр 48548,5 сая төгрөгийн тэтгэврийг олгосон. Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу хуульд заасан хугацаанд зарцуулсан байна. Үүнд: Сан Гүйцэтгэл /сая.төг/ Тэтгэвэр - 48548,5 Тэтгэмж - 21529,6 ҮОМШӨ - 23342,8 Ажилгүйдэл - 1127,7	99.7
2.1.11.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн тайлан гаргах ажлыг зохион байгуулах	Шаардлагагүй	Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлнэ.	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлагын сарын мэдээг гаргаж, ирүүлсэн.	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлагын сарын мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн байна.	Системийн шинэчлэл, хөгжүүлэлтэй холбоотой 2024 оны 1,3 дугаар улирлын сангийн санхүүгийн тайланг гаргаагүй ба хагас жилээр буюу 2 дугаар улирлаар Э-тайлан гаргасан. 2024 оны жилийн эцсийн тайланг сикос системээр гаргахаар бүтээгдэхүүн тус бүр дээр өөрчлөн тогтоох, залруулах зэрэг ажлыг хийж байна.	90.0
2.1.15.	Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг тухай бүр	Шаардлагагүй	Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв оруулж бүртгэнэ.	Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэсэн.	а) Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх	Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байхад анхааран ажиллаж	

	үнэн бүрдүүлэх	зөв			ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх. б) Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлсэн байна.	байна. 2024 оны 1-р сараас хэрэгжүүлсэн мэдээллийн шинэ системийн хөгжүүлэлттэй холбоотой тэтгэвэр, тэтгэмжийг хуулийн хугацаанд тогтоож олгохын тулд өмнө хэрэглэж байсан программаар тогтоон гараар олгох, хөгжүүлэлт хийгдсний дараа шинэ системд мэдээллийг оруулах, бүртгэх, залруулах ажлуудыг бүтэн жилийн турш хийж ажиллалаа. Системийн хөгжүүлэлттэй холбоотой тэтгэврийн олголт буруу хийгдэх, алдаа гарсан эсэхийг шалгах, илүү дутуу олголтыг шалгаж, жагсаалтаар тэтгэвэр олгох зэрэг механик ажил ихсэж байцаагч нарын ажлын ачаалал эрс нэмэгдлээ.	85.0
--	-------------------	-----	--	--	---	--	------

Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт

Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах

4.1.1.	Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг	Шаард-лагагүй	Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна.	2023 оны жилийн эцсийн байдлаар аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд НДЕГ-аас өгсөн үүрэг даалгавар, тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, зорилтот жилийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн авч дүгнэхэд нийт салбарын хэмжээнд хэрэгжилт 83,5%-тай хэрэгжсэн байна	Өгсөн үүрэг даалгаврыг цаг нь хэрэгжүүлж, биелэлтийг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ.	Нийгмийн даатгалын хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан түүнийг дагалдан гарах журам, эрх зүйн бусад баримт бичгийг Засгийн газар, холбогдох яам, агентлагаас баталж, 2024.01.01-ний өдөр буюу хууль хүчин төгөлдөр хэрэгжих хугацаанаас дагаж мөрдөхөөр зохицуулсан. Шинээр батлагдсан 4 хууль, 56 эрх зүйн актаас холбогдох албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа.	85.0
--------	--	---------------	--	---	---	--	------

	хугацаанд хүргүүлэх	нь					
4.1.2.	ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах	Шаард- лагагүй	Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байна.	Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлт 2023 онд 100%-тай хэрэгжсэн байна.	Иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, мэдээг үнэн бодит гаргаж улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ.	Нийгмийн даатгалын байгууллагаас үйлчилгээ авах хүсэлт ирүүлсэн иргэд, даатгуулагчдын хүсэлтийг өргөдөл, гомдлын дэвтэрт бүртгүүлж, өргөдлийн бүртгэл хөтөлж, шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллаж байна. 2024 оны 11 сарын байдлаар нийт 803 хүсэлт хүлээн авч шийдвэрлэн, системийн хөгжүүлэлттэй холбоотой шийдвэрлэж болохгүй байгаа хүсэлтийг иргэд даатгуулагчийг хохироолгүй өргөдөл өгсөн хугацаанаас тооцож тогтоож байна. Тэтгэвэр авагч тэтгэвэр авах банкаа өөрчлүүлэх 385 хүсэлтийг хүлээн авч холбогдох банктai мэдээлэл шуурхай солилцож тухай бүрт нь шийдвэрлэж ажиллалаа. Тайлант хугацаанд 96 даатгуулагчид нас барсаны дараа сарын тэтгэвэр олгосон. Хуульд заасан тэтгэврийн тусгай зохицуулалтаар нөхцөл хангасан 26 иргэний өндөр насны тэтгэврийг 20 хувиар нэмэгдүүлэн тогтоож, олгоод байна. Цэргийн алба хаасны тэтгэвэр авагч 1 хүн болзол хангаагүй тул татгалзаж шийдвэрлэсэн. Нийгмийн даатгалын цогц системийг хөгжүүлж, нэвтрүүлэх ажлаас шалтгаалан зарим даатгуулагчдын тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь тогтоох, олгох ажлууд удааширнаас үүдэн Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд бүртгэгдсэн тус газрын үйлчилгээтэй холбоотой 5 гомдол, 1 санал, иргэн биечлэн ирж гаргасан 1 гомдол, нийт 7 гомдол, саналыг 24	98.8

						цагт багтаан 100% шийдвэрлэж, даатгуулагчдад тухай бүр мэдээлэл хүргэж ажиллалаа.	
4.1.7.	Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх	Шаардлагагүй	Авлигаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулсан байна.	Газрын ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах.	Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.	Авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор боловсруулан батласан төлөвлөгөөг 94%-иар хэрэгжүүлэн ажиллав. АТГ-аас зохион байгуулсан 2 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор төрийн захиргааны 8 албан хаагчийг оролцуулсан. Багануур дүүргийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр баталсан "Авлигын эсрэг олуулаа нэгдье" аянд нэгдэн дэмжиж ажиллалаа. Тайлант хугацаанд авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн тохиолдол гараагүй болно.	94.0
4.1.8.	Нийгмийн даатгалын газрын ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг ханган ажиллах	Шаардлагагүй	НДЕГ-ын 2016.12.07-ны өдрийн "Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч (ажилтан)-ийн үйлчлүүлэгчтэй харилцах журам" батлах тухай А/61 дүгээр тушаал, 2019.12.13-ны өдрийн "Нийгмийн даатгалын хэлтэс (тасаг)-ийн ажлын байр, үйлчилгээний орчны стандарт" батлах тухай А/194 дугаар тушаалын хэрэгжилтийг	-	Нийгмийн даатгалын газрын ажилтан албан хаагчдын харилцаа хандлагыг сайжруулж, ажлын байр, үйлчилгээний орчны стандарт хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019.12.13-ны өдрийн А/194 дүгээр тушаалаар баталсан "Нийгмийн даатгалын хэлтэс (тасаг)-ийн ажлын байр, үйлчилгээний орчны стандартыг ханган ажиллахад анхаарч, өөрчлөлт, шинэчлэлтийг тогтмол хийж хэрэгжүүлж байна. Иргэд даатгуулагчдад ойлгомжтой байлгах үүднээс үйлчилгээний А,Б заалны байцаагч ажилтнуудын өмнө нэр, албан тушаал, ажил үүргийн чиглэлийг байцаагч солигдох тухай бүр шинэчилж байна. Байцаагч нарын утсан харилцаа, зөвлөгөө мэдээллийг бүрэн гүйцэд хүргэж ажиллаж байгаа эсэхэд өдөр тутмын хяналт тавьж зөвлөн туслаж ажиллаж байна.	98.2

			мөрдөж ажилласан байна				
Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах							
4.2.1.	Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах	441,0 мян.төг	Хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамруулсан хүний тоо	Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх 27 удаагийн сургалтад давхардсан тоогоор 243 албан хаагчийг хамруулсан.	-Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх танхимын болон цахим сургалт зохион байгуулна. -Шинэ ажилтныг ажлын байран дээр дадлагажуулах сургалт зохион байгуулж, хөрвөх чадвар бүхий мэргэжилтэн бэлтгэнэ.	Тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөл, НДЕГ, Багануур дүүргийн ЗДТГ, бусад байгууллагаас цахим болон танхимаар зохион байгуулсан 50 удаагийн сургалтад оролцож, мэргэжлийн болон холбогдох бусад сэдвүүдээр мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн байна. НДЕГ, Хэлний бодлогын зөвлөл хамтран 2024 оны 06 дугаар сарын 10-наас мөн оны 07 дугаар сарын 04-ний өдрийн хугацаанд монгол бичгийн 10 удаагийн цахим сургалтад хамрагдаж 2 албан хаагч цахим сертификат авсан. Улсын байцаагчийн шалгалтад бэлтгэх цахим хичээлд 3 албан хаагчийг хамруулсан.	100
4.2.3.	Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр өргөнөөр сурталчлах		Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг сурталчлах зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл, Нийгмийн сүлжээний хуудас (фэйсбүүк)-д байршуулсан	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр сурталчилгаа хийсэн 62 тоо, мэдээллийн төрөл 7	Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээ болон бусад хэлбэрээр олон нийтэд ойлгомжтой, шуурхай хүргэсэн байна. ХНХЯ болон НДЕГ-аас бэлтгэсэн мэдээллийг бүх	Багануурын мэдээ цахим хуудсанд Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулга, Багануур дүүргийн нийгмийн даатгалын газрын цаг үеийн мэдээлэл, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах өдөр газрууд зэрэг мэдээллийг цаг тухайд нийтлэн ажилласан. 9 дүгээр сард "Нээлттэй мэдээллийн сар" ажлын хүрээнд хэлтсийн 3 байцаагч оролцож хуваарьт 2 газруудад болон 1, 2, 3 дугаар хорооны малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ажлын байранд очиж зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.	95

			мэдээллийн тоо, хандалтын тоо. Бэлтгэсэн нэвтрүүлэг, видео шторк, контент, цахим хичээл, постерын тоо. Иргэд, даатгуулагчид, ажил олгогчид, зорилтот бүлгүүд буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчдад чиглэсэн сурталчилгааны тоо, төрөл зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл		албан хаагчдаар цааш түгээлгэж, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан байна.	
Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эмнэлэг хөдөлмөрийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх						
4.3.1.	Эрүүл мэндийн магадлалын талаарх хууль тогтоомжийн биелэлтийг ханган ажиллах	Шаард-лагагүй	Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгаан шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад жилд 4-өөс доошгүй удаа хяналт хийсэн байна.	Зохион байгуул-сан ажлын тоо, тайланг ЭММТЗ-д хүргүүлсэн байна.	Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгаан шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад хяналт хийж холбогдох арга хэмжээ авсан байна.	Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Нийслэлийн Эрүүл мэндийн газартай зөвшилцөн санал авч, НДЕГ-ын даргын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 38 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан. Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурал 7 хоногийн Лхагва гарагийн 15:00 цагт, Нийгмийн эрүүл мэндийг дэмжих төвд 80-100% ирцтэй хуралдаж, өвчтөний бичиг баримтад үндэслэн нийт 36 удаа хуралдаж, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, хэмжээг 77 иргэнд шинээр тогтоож, 33 иргэний ХЧА-ын хувь хэмжээг цуцалж, 419 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг сунгаж шийдвэрлэсэн. Дүүргийн хэмжээнд нийт 902 иргэн

97.5

					хөдөлмөрийн чадвар алдалтын тэтгэвэр тогтоолгон авч байна. Энэ нь дүүргийн нийт хүн ам /29342/-ын 3 хувийг эзэлж байна. ЭММЗ-ийн хурал эхлэхээс өмнө хурлаар орох иргэдийн нэрсийн жагсаалтыг гишүүдэд танилцуулж, ашиг сонирхлын зөрчилтэй эсэх мэдүүлгийг амаар авч ашиг сонирхол үүссэн бол маягт бөглөн хурлын даргад танилцуулан шийдвэрлэн ажиллаж хэвшсэн. ЭММЗ-ын хурлын үйл явцыг дүрс бичлэгт буулган, цахим хэлбэрээр тухайн сардаа хадгалан ажилладаг.	
			Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээллийн цахим сангийн бүрдүүлэлтэд жилд 2 –оос доошгүй удаа тулгалт хийж зөрчил дутагдлыг тухай бүр арилгах арга хэмжээ авч ажилласан байна.	Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээллийн цахим сангийн бүрдүүлэлтэд жилд 2 –оос доошгүй удаа тулгалт хийж зөрчил дутагдлыг тухай бүр арилгах арга хэмжээ авч ажилласан байна.	Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийн хяналтыг улирал тутам тулган зөрүү гарахаас урьдчилан сэргийлж, нийгмийн даатгал, нийгмийн халамж, зөвлөлийн мэдээлэл, хорих ангийн тэтгэвэр авагчдын мэдээллийг тулган хянаж ажилладаг. Хагас жилийн хяналтаар 951 иргэний мэдээлэлд тулгалт хийж хянахад нас барсан 11, шилжсэн 6, шилжиж ирсэн 13, шимтгэл төлсөн хугацааг үндэслэн 3 хүний мэдээлэлд хөдөлгөөн хийж зөрүүг арилгалаа.	100
4.3.2.	Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах арга хэмжээ зохион байгуулсан байх	Шаард- лагагүй	Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт, шалгалтыг хагас жил тутам зохион байгуулж, үр дүнг тооцсон байна.	Зохион байгуулсан ажлын тоо, тайланг ЭММТЗ-д хүргүүлсэн байна.	ЭММЗ-ийн шинэчлэгдсэн дүрмийн дагуу иргэнийг хуралд биеэр ирүүлэхгүй хөдөлмөрийн чадвар алдалтын шийдвэрийг гаргах чиглэлийг хэрэгжүүлэн ажиллав. Зарим тохиолдолд хурлаар танилцуулагдаж буй өвчтөний холбогдох бичиг баримт, оношийн баталгаажилтыг давхар магадлан хянаж, эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөөг ярилцаж, төлөвлөн, мэдээлэл солилцож, өвчтөнийг цаашид зөв чиглүүлэх талаар чиглэл	100

						өгч, дотоодын хяналтыг тасралтгүй явуулдаг. Ердийн өвчний заавар батлагдан гарсан нь оношийн үндэслэлийг батлах, эмч мэргэжилтэнд нэгдсэн арга зүйгээр зөвлөгөө өгөх зэрэг хэрэгтэй эмхтгэл болсон.	
			Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд оролцогчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ижил мэргэжилтний үзлэгийг 2-оос доошгүй удаа зохион байгуулсан байна.		Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд оролцогчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ижил мэргэжилтний үзлэгийг зохион байгуулж эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ур чадвар сайжирч иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх үйл ажиллагаа ижил түвшинд хүрсэн байна.	ЭММТЗ-с удирдамж гарган 3 аймаг, нийслэлийн дүүргүүдийн ЭММЗ-н тус бүр эмчийг хамруулан өвчтөний амбулаторийн картанд 2024.06.14 өдөр цахимаар ижил мэргэжилтний үзлэгийг зохион байгуулсан. Тус дүүргээс 1 өвчтөний мэдрэлийн амбулаторийн картыг цахимжуулан хүргүүлж, бусад орон нутгийн 4 мэдрэлийн амбулаторийн картанд үнэлгээ хийж, цахимаар оролцож, мэдээлэл солилцон ажилласан.	100
4.3.3.	Эрүүл мэндийн магадлалын оролцогч талуудын үйл ажиллагааг нэгтгэн хэрэгжилтийг ханган ажиллах	Шаард-лагагүй	Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах жилийн төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэн ажиллана.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн болон судалгааны тайланг ЭММТЗ-д хүргүүлнэ.	Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах төлөвлөгөө гарган, хэрэгжүүлсэн байна.	Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлж, бууруулах зорилгоор хурлаар орж буй эмчийн амбулаторийн картанд ижил мэргэжилтний үзлэг хийж оношийн баталгаажилтыг хянан магадалж, тухайн өвчтөнийг эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөөний санал, мэдээлэл солилцож арга зүйн зөвлөгөөг өгч ажилладаг. Зөвлөлийн гишүүд өөр өөрийн үүрэгтэй ажилладаг бөгөөд өвчтөний хяналтын карт хөтлөлт, амбулаторийн картанд эмчлэн	98

					эрүүлжих төлөвлөгөөг бичсэн эсэх хяналтыг мэдрэлийн төрөлжсөн мэргэжлийн эмч, эмнэлгийн хувийн хэргийн бүрдэл, бичилтийг мэс заслын төрөлжсөн мэргэжлийн эмч, өвчтөний амбулаторийн картанд хөдөлмөрийн чадвар алдалтын шийдвэрийн наалт, бичилтийг дотрын төрөлжсөн мэргэжлийн эмч, өвчтөнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хууль, эрх зүй, журмын мэдээлэл өгч, мэдээллийн сангийн үнэн зөв байдал, өвчтөний бичиг баримтад хяналт тавьж, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, заалт, оношийг бодитой зөв гаргах зэргийг магадлан, хурлын үйл ажиллагааг тасралтгүй явуулах, уялдаа холбоог ханган ажиллалаа.		
			Орон нутгийн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд суурь болон харьцуулсан судалгаа хийж, тодорхой арга хэмжээ авч орон нутгийн удирдлага, холбогдох байгууллагад танилцуулсан байна.		Орон нутгийн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд суурь болон харьцуулсан судалгааг хийж дүгнэсэн байна.	Тус дүүргийн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн тоог дүүргийн нийт хүн амын тоотой /29342/ харьцуулбал 2015 онд 3,67 байсан бол жил бүр тогтмол дүнгээр буурч, 2023 оны жилийн эцсээр хүн амын 2,9 хувийг эзэлж байна. Сэтгэцийн эмгэг, дотрын өвчин, мэдрэлийн эмгэг, сонсгол тэнцвэрийн эрхтний эмгэг, нүд, гэмтлийн эмгэгүүд хөдөлмөрийн чадвар алдалтын 90 гаруй хувийг эзэлж байна. Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн 70 гаруй хувь нь ажилгүй, 31-59 насны хөдөлмөрийн насны 78% иргэн байна.	100
4.3.4.	Эрүүл мэндийн магадлалын талаарх хууль тогтоомжийн талаар болон	Шаард-лагагүй	Төрөлжсөн мэргэшлийн болон сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч,	Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний	Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн болон төрөлжсөн мэргэшлийн, сум,	Эрүүл мэндийн магадлалтай холбоотой тушаал шийдвэрийг тухай бүр холбогдох эмч, мэргэжилтнүүдэд танилцуулж, хэрэгжилтийг ханган хамтарч ажилладаг.	

авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах	мэргэжилтнүүдэд эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль тогтоомжийн талаар болон авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр жилд 2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна.	тоо, тайланг хүргүүлсэн байна.	ерхийн Эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулж шинэ мэдээ, мэдээллийг хүргүүлж ажилласан байна.	ЭММТЗ-өөс АТГ-тай хамтран 2024.05.24-ний өдөр ЭММЗ-ийн гишүүдэд цахимаар зохион байгуулсан сургалтад гишүүд 100% хамрагдсан бөгөөд хурлаар орж буй өвчтөн зөвлөлийн гишүүнтэй ашиг сонирхлын зөрчил үүсэх тохиолдол бүрд хурлын гишүүнээр тусгай маягт бөглүүлэн зөвлөлийн даргад танилцуулан журмын дагуу ажиллаж хэвшсэн. Энэ онд тохиолдол гараагүй. Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулсан төвийн бүсийн зөвлөгөөнд магадлагч эмч, орлогч дарга, дотор, мэс, мэдрэлийн төрөлжсөн мэргэжлийн эмч нар оролцсон.	98,0
Гүйцэтгэлийн дундаж хувь:					97,3
Гүйцэтгэлийн нийт дундаж хувь:					89,1

ТАЙЛАНГ ХЯНАСАН:
БАГАНУУР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА

2024 оны 12 дугаар сарын 02

Р.ӨНӨРЖАРГАЛ

ТАЙЛАГНАСАН:
БАГАНУУР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ТЭТГЭВЭР
ТЭТГЭМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

2024 оны 12 дугаар сарын 02

Д.ХЭРЛЭН



БАГАНУУР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА ДАМБИЙН
ХЭРЛЭНГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар

Нэгжийн нэр: Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт (70 оноо)
1	2	3	4
1.	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	Биелэлтийн хувь = (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хувь)	(Биелэлтийн хувь * 70 / 100%)
Зорилт 1. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт			
1	Арга хэмжээ 1.1.1		68.4
Зорилт 2. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт			
1	Арга хэмжээ 2.1.7		3.5
2	Арга хэмжээ 2.1.9		69.79
3	Арга хэмжээ 2.1.11		63.00
4	Арга хэмжээ 2.1.15		68.5
Зорилт 4. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт			
1.	Арга хэмжээ 4.1.1		59.5
2.	Арга хэмжээ 4.1.2		69.16
3.	Арга хэмжээ 4.1.7		65.8
4.	Арга хэмжээ 4.1.8		70.0
5.	Арга хэмжээ 4.2.1		70.0
6.	Арга хэмжээ 4.2.3		68.5
7.	Арга хэмжээ 4.3.1		70.0
8.	Арга хэмжээ 4.3.2		70.0
9.	Арга хэмжээ 4.3.3		70.0
10.	Арга хэмжээ 4.3.4		70.0
Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт			
1.			
2.			
Дундаж оноо:			63.47

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Арга хэмжээ 1.		15.0
2.	Арга хэмжээ 2.		12.0
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			13.5

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	15.0
2.	Удирдан зохион байгуулах	15.0
3.	Асуудал шийдвэрлэх	15.0
4.	Манлайлах	15.0
5.	Багаар ажиллах	15.0
6.	Харилцаа	15.0
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
7.	Мэргэжлийн ур чадвар 1.	
8.	Мэргэжлийн ур чадвар 2.	
9.	Мэргэжлийн ур чадвар 3.	
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		15.0

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)	70 хүртэлх оноо 63.47
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	15 хүртэлх оноо 13.5
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	15 хүртэлх оноо 15.0
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	 оноо -
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо		91.97

Үнэлгээ өгсөн:
Газрын дарга

Р.Өнөржаргал



2024 оны 12 дугаар сарын 02..

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:
Тэтгэвэр, тэтгэмжийн
хэлтсийн дарга

Д.Хэрлэн

2024 оны 12 дугаар сарын 02..